

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ЗӨВЛӨМЖ

2024.08.15

Дугаар 2024/02

Улаанбаатар хот

“Дүүргийн төр захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа,
Бодлогын баримт бичгийн 2024 оны эхний хагас жилийн
хэрэгжилтийн явцын тухай”

Үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон бусад холбогдох эрх зүйн актуудыг удирдлага болгосон бөгөөд харьяа байгууллагын үйл ажиллагаанд анхаарах дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

1.1 Бодлогын хэрэгжилт буюу төлөвлөсөн арга хэмжээний эерэг, сөрөг үр нөлөөний талаарх тоон үзүүлэлтийг агуулга, зорилгоор нь нэгтгэн өсөлт бууралтыг харьцуулж хувиар илэрхийлэх,

1.2 Тайлант хугацаанд ямар нэг өөрчлөлт ороогүй, шинээр ямар нэг юм хийгдээгүй тохиолдолд шалтгаан нөхцөлийн талаар тайлбар бичих,

1.3 Үр дүнгүй болон эрчимжүүлэх шаардлагатай, хэрэгжих хугацаа болоогүй арга хэмжээнд онцгой анхаарч, хэрэгжилтийг бүрэн хангаж, бүрэн гүйцэд, найруулга зүйн алдаагүй, 2000 тэмдэгтэд багтаан тоон үзүүлэлтийн өөрчлөлт, үр дүнг нягталж тусгах нь зүйтэй.

Нийслэлийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөнөөс хугацаа болоогүй болон үр дүнгүй хэрэгжилттэй 9 арга хэмжээ:

№	Зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Зорилтот түвшин үр дүн 2024 он
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ БОДЛОГО				
Боловсрол				
2.3. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлсэн, суралцагчийн хөгжлийг дэмжсэн “Нийслэлийн боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.				
16	2.3.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг сайжруулж, хүүхдэд ээлтэй эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ.	2.3.3.1. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт их засвар, дулаан техникийн шинэчлэлийн төслийг хэрэгжүүлж сургалтын орчинг сайжруулна.	ТГУХ, ТНААХ, НБХ, БХ	85 байгууллагыг их, засвар, дулаан техникийн шинэчлэлийн төсөлд хамруулсан байна.
Хөдөлмөр эрхлэлт				
2.5. Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.				
27	2.5.1. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжин цагаар ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.	2.5.1.2 Оюутан, залуучуудыг цагаар ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлэн, суралцах хугацаанд нь	НХХ, ХөХҮХ	7,000 оюутан залуучуудыг цагийн ажилд хамруулсан байна.

№	Зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Зорилтот түвшин үр дүн 2024 он
		хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй болгоно.		
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО				
Ногоон байгууламж бүхий хот				
5.1 Байгалийн нөөц баялаг, экосистемийн үнэ цэнийг хадгалж, хамгаалах, нөхөн сэргээх, усны нөөц, урсац бүрэлдэх эхийг хамгаалалтад авч, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.				
39	5.1.1.Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	5.1.1.1.Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэцэрлэгт хүрээлэн байгуулж, олон нийтийн амралт зугаалгын талбай байгуулна.	ТНААХ	1 цэцэрлэгт хүрээлэн байгуулсан байна.
40	5.1.1.Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	5.1.1.3.Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хэмжээг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтын менежментийн ажлыг сайжруулна.	ТНААХ, ХОРООД	Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 0.64 м2-аар нэмэгдүүлсэн байна.
41	5.1.1.Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	5.1.1.4.Хотын ногоон байгууламжийн эрх зүйн орчин, санхүүжилтийн эх үүсвэрийг сайжруулна.	ТНААХ	Өөрийн хөрөнгөөр гадна талбайн ногоон байгууламж нэмэгдүүлсэн ААНБ нэмэгдсэн байна.
42	5.1.1.Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	5.1.1.5.Гэр хорооллын айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулахыг дэмжиж ажиллана.	ТНААХ, ХОРООД	Хашаандаа ногоон байгууламж, мод тарьсан айл өрхийн тоо нэмэгдсэн байна.
43	5.1.1.Нийслэлийн ногоон байгууламжийг сайжруулах оновчтой менежментийг хэрэгжүүлэн, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	5.1.1.6.“Шарилжгүй Улаанбаатар” аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	ТНААХ	4 сая м2 талбайд шарилж зэрлэг ургамлыг устгасан.
Утаагүй хот				
5.2. Агаар, орчны бохирдлыг бууруулж, байгальд ээлтэй, үр ашигтай хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.				
46	5.2.6. Бохирдож доройтсон, үржил шимээ алдсан хөрсийг нөхөн сэргээх хүн амын эрүүл мэндийг хамгаалах, салбар дундын уялдааг хангасан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх “Хөрсний бохирдолгүй хот” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	5.2.6.3.Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	ТНААХ	2,000 өрхийг стандартын шаалдлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгосон байна.

№	Зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Зорилтот түвшин үр дүн 2024 он
47	5.2.7. Хог хаягдлыг ангилал, боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихэд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж цогц бодлогыг хэрэгжүүлнэ.	5.2.7.3.Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ.	ТНААХ	Цахим системийн нэвтрүүлэлтийн хувь хэмжээ-100 хувь

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөнөөс үр дүнгүй хэрэгжилттэй 31 арга хэмжээ:

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
НЭГ. ЭКО ДҮҮРЭГ-НОГООН ХӨГЖИЛ			
1.1. Ногоон байгууламж			
1.1.1 Нийтийн эзэмшлийн гудамж талбайд эко бичил цэцэрлэгт хүрээлэнг бий болгож иргэд олон нийт чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх амралт зугаалгын бүсийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн ногоон байгууламжийг тоолж, бүртгэж мэдээллийн сан үүсгэж, баяжуулж ажиллана.	ТНААХ	Шинээр хийгдсэн ногоон байгууламжийг бүртгэлжүүлж, мэдээллийн сангийн баяжилтыг 95% -д хүргэнэ.
1.1.2 Туул, Дунд голыг түшиглэн иргэд 4 улирлын турш амарч, зугаалах зориулалт бүхий тохилог орчныг бүрдүүлнэ. Шаардагдах төсөв	Туул, дунд голын дагуу байршилд иргэдийн амарч, зугаалах бүс байгуулна.	ТГУХ, ТНААХ	1-2 байршилд амралт зугаалгын бүс байгуулсан байна.
1.2. Агаар, орчны бохирдол			
1.2.2 Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбоно.	Төрийн өмчийн халаалтын зуухнуудыг төвлөрсөн дулаанд холбох ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ	ТГУХ, ТНААХ	1-ээс доошгүй халаалтын зуухыг төвлөрсөн дулаанд холбоно.
1.2.4 Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	Нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	ТНААХ	13855 нүхэн жорлон, 8340 бохирын цооногийг 100% ариутгаж халдваргүйжүүлсэн байна.
1.3 Хүнс, хөдөө аж ахуй, инноваци			
1.3.2 Газар тариалан эрхлэгчдэд экологийн цэвэр бордоо ашиглах, экологийн цэвэр тариалан эрхлэхэд нь мэргэжлийн дэмжлэг үзүүлэн "Хан-Уулд тариалав" брэнд бий болгоно.	"Хан-Уулд тариалав" брэнд бий болгоно.	ХҮХҮХ, ЖДҮДТ	2 оос доошгүй Брэнд бүтээгдэхүүнтэй болсон байна.
1.3.4 Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийг нээнэ.	Мэдээлэл технологийн старт ап компаниудад зориулсан инкубатор төвийг нээнэ.	ТГУХ, ХХҮХ	Барилга ашиглалтад орж, үйл ажиллагаа эхэлсэн байна.
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ			
2.1. Биеийн тамир, спорт			
2.1.1 Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр өргөн хүрээнд зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	Дүүргийн "Иргэдийн спортын их наадам"-ыг жил бүр зохион байгуулна.	НХХ, БТСХ	Иргэдийн наадамд 3900 иргэн хамруулсан байна.
2.2. Эрүүл мэнд			

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
2.2.2 Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.	Сүрьеэгийн эрт илрүүлгийг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг хангах зорилгоор сүрьеэгийн төвийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, тоог нэмэгдүүлнэ.	НХХ, ЭМТ, НЭ	Сүрьеэгийн урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг шинэ нэмэгдүүлж, тохиолдлын түвшин 10000 хүн тутамд 11.5-д хүргэнэ.
2.2.4. Эх хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулна.	Хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна.	НХХ, ЭМТ, НЭ	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 6.2 байна. 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 0.97 байна.
2.2.7. Жишиг нэгдсэн эмнэлгийн загвараар дүүрэгт нэгдсэн эмнэлэг байгуулна.	Жишиг загвараар нэгдсэн эмнэлэг байгуулах ажлыг хамтран зохион байгуулна.	ТГУХ, ХУДНЭ	Барилгын ажлын гүйцэтгэлээр 70 хувьд хүрсэн байна.
2.2.9 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор "Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулна.	Харшлын өвчин үүсгэгч шарилж, газрын хөл ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	ТНААХ	"Шарилжгүй эрүүл дүүрэг аян"-г зохион байгуулж 70,000-аас доошгүй м2 талбайн шарилж хог ургамлыг устгасан байна.
2.4. Хотын соёл			
2.4.2 Иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс үндэсний бахархал, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж хэвшүүлнэ.	Соёл, гоо зүйн боловсролын агуулгын хүрээнд Богцон дахь соёлын өв сэдэвт олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулна. Түүх, соёлын үл хөдлөх өвийг хадгалж, хамгаалах, сэргээн засварлах ажлыг хэрэгжүүлнэ.	НХХ, АБНТБТ НХХ, СО	100-аас доошгүй хүнийг хамруулна. Шаардлагатай соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээ авна.
ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ-ИРГЭН БҮРТ			
3.1 Иргэн төвтэй үйлчилгээ			
3.1.2 Байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор "Чанарын удирдлагын тогтолцоо"-г нэвтрүүлэх ажил зохион байгуулж, хороодын үйл ажиллагааны чадавхийг сайжруулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Хороодын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	"Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандарт нэвтрүүлнэ.	ТЗУХ	-
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ			
4.2. Нийгмийн халамж			
4.2.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулж, нөлөөллийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн "Уулзалт өдөрлөг", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах Олон улсын өдөр"-ийг угтсан арга хэмжээ зохион байгуулна.	ХөХҮХ, НХХ	375-аас доошгүй иргэнийг хамруулсан байна
4.3. Хөдөлмөр эрхлэлт			
4.3.2 Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	"Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл" бүлгээр ажиллах чадвар олгох сургалт зохион байгуулж гэрчилгээ олгоно.	ХүХҮХ, ХөХҮХ, ЖДҮДТ	40-аас доошгүй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг хамруулна.

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
4.3.3 Цагийн ажлын байрыг дэмжиж нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах	ХөХҮХ	150-аас доошгүй оюутанг цагийн ажилд зуучилна.
4.4. Дүүргийн төсөв, санхүү			
4.4.4 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.	Дотоодын давуу эрх тооцох боломжтой төсөл арга хэмжээнд тухай бүрт тусгаж ажиллах	ХААА	Нийт арга хэмжээний 70%-д дотоодын давуу эрх тооцохоор тусгасан байна.
4.5. Гэр бүл			
4.5.1 Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж, Хүүхэд, гэр бүлд ээлтэй байгууллага, шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна.	Гэр бүл хүүхэд залуучуудад ээлтэй байгууллага, аж ахуйн нэгж, Шилдэг гэр бүлийг шалгаруулан олон нийтэд сурталчилна.	НХХ, ГБХЗХХ	5 байгууллага, 5 гэр бүлийг шалгаруулан сурталчилна.
	Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан Төрөлт, гэрлэлтийн бүртгэлийг ёслолтой бүртгэх	НХХ, ГБХЗХХ	100 иргэн хамруулна.
4.5.3 Төр хувийн хэвшлийн түншлэлээр залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий “Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Залуу иргэд гэр бүлээрээ амрах зориулалт бүхий “Эко зуслангийн хотхон, зуслангийн түрээсийн байр” байгуулж ашиглалтад оруулна.	ТГУХ, ТНБГХХ	Эко зуслангийн барилгын ажлыг эхлүүлнэ.
4.5.5 Хараа хяналтгүй, Хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэх "Хүүхэд хамгаалал-Хяналт" нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд хамруулж, хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсэн хүүхдийн тоог бууруулна.	Хараа хяналтгүй хүүхдийг илрүүлэх "Хүүхэд хамгаалал-Хяналт" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	НХХ, ГБХЗХХ, ЦГ	4 удаагийн арга хэмжээ зохион байгуулна.
ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ			
5.1 Газрын харилцаа			
5.1.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг Улсын хаягийн нэгдсэн системтэй холбож, хаягжилтын нэгдсэн стандартад шилжүүлэх ажлыг талуудтай хамтран дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.	Дүүргийн нутаг дэвсгэр дэх геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого хийж, бүртгэлжүүлэх, хадгалалт, хамгаалалтыг эзэнжүүлэх	ГЗБА	Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн хадгалалт хамгаалалтыг эзэнжүүлж гэрээ байгуулна 100 хувь.
5.1.2 “Орц-Гарц” арга хэмжээг хэрэгжүүлж, гэр хорооллын мухар гудамж, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн асуудлыг шийдвэрлэж түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх боломжийг бүрдүүлнэ.	Дүүргийн хэмжээний Гэр хорооллын мухар гудамж, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн судалгаа гаргаж, зөрчлийг арилгуулах "Орц-гарц" арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлнэ.	ГЗБА, ТНААХ	Зөрчлийн тоо бууруулж, хуулийн хэрэгжилтийг хангуулна.
5.1.3 Хууль зөрчиж олгогдсон болон газраа зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчилтэй газруудын зөрчлийг арилгуулж, шаардлагатай тохиолдолд газар чөлөөлөх арга хэмжээг холбогдох эрх бүхий	Хууль зөрчиж олгогдсон болон газраа зориулалтын дагуу ашиглаагүй зэрэг зөрчилтэй газруудын зөрчлийг арилгуулж, шаардлагатай тохиолдолд	ГЗБА	Хуулийн хэрэгжилтийг хангах, газар ашиглалт сайжрах.

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх		
5.1.4 Гэр хорооллын гэрэлтүүлэг, зам талбай, хайс хашаа, барилгын түр хашаа болон бусад тохижилтын ажлуудад хотын стандарт, жишгийг мөрдүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.	Стандартын шаардлага хангасан гэрэлтүүлгийг шаардлагатай байршуудад байршуулна.	ТГУХ, ТНААХ	Стандартын шаардлага хангасан 100 ширхэг гэрэлтүүлгийг байрлуулсан байна.
5.1.5 Биокомбинат, Туул, Өлзийт хороодод нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг суурь судалгаанд үндэслэн боловсруулж, бүс нутгийн газар ашиглалтыг сайжруулна.	Эзэмшлийн газраа 2-оос дээш жил ашиглаагүй иргэд хуулийн этгээдийн газар эзэмших эрхийг хүчингүй болгуулж, дахин олголт хийх, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	ТГУХ, ГЗБА	Бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн газар ашиглалт сайжруулах дахин төлөвлөлт хийх.
5.2 Орон сууц			
5.2.1 Гэр хорооллын дахин төлөвлөлтийг иргэд оршин суугчдын харилцан ойлголцлын үндсэн дээр талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Нисэх, Яармагийн гэр хорооллыг дахин төлөвлөлтөөр бие даасан болон төвлөрсөн инженерийн шугам сүлжээтэй, нам давхрын болон амины сууцны хороолол болгох ажлыг тууштай хэрэгжүүлнэ.	ТГУХ	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлээр.
5.2.2 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажлыг үргэлжлүүлнэ.	Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцны хэрэгжиж буй төслүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран үргэлжлүүлнэ.	ТГУХ	Дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны эрчимжүүлнэ.
5.5 Инженерийн бэлтгэл арга хэмжээ			
5.5.3 Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын бүсийг нарийвчлан тогтоож тус бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг нүүлгэн шилжүүлж, хамгаалалтын бүсийн газрыг албажуулна.	Үерийн аюултай бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.	ТНААХ, ГЗБА, ОБ	Зөрчлийн тоо буурах, хуулийн хэрэгжилтийг хангах.
5.6 Усан хангамж, ариутгах татуурга			
5.6.5 Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож баталгаажуулна.	Усны эх үүсвэр, цэвэрлэх байгууламж болон шугам сүлжээ, барилга байгууламжийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд өртсөн иргэн, хуулийн этгээдийн судалгааг гаргаж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулна.	ТНААХ, ГЗБА	Зөрчлийн тоо буурах, хуулийн хэрэгжилтийг хангах.

Үнэлэх боломжгүй, хэрэгжих хугацаа болоогүй 13 арга хэмжээ:

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
НЭГ. ЭКО ДҮҮРЭГ-НОГООН ХӨГЖИЛ			
1.2. Агаар орчны бохирдол			
1.2.3 Агаарын бохирдлын эх үүсвэр, хор уршиг, дэвшилтэт техник технологи, ногоон амьдралын хэв маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн	Агаарын бохирдлыг бууруулах, зөв дадал хэвшүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Цэвэр агаар – Цэлмэг тэнгэр” арга	ТНААХ	2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулж, 4 төрлийн зөвлөмж сэрэмжлүүлэг тараана.

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
оролцоог нэмэгдүүлэх, зэрэг мэдээлэл сурталчилгааны ажил зохион байгуулна.	хэмжээг бүсчлэн зохион байгуулна.		
1.3. Хүнс, хөдөө аж ахуй, инноваци			
1.3.1 Дүүргийн өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих "Эко хүлэмж" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Газар тариалан эрхлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэх үзэсгэлэн худалдаа зохион байгуулна.	ХХҮХ, ЖДҮДТ	20-аас доошгүй тариаланчийг намрын үзэсгэлэн яармаг худалдаанд хөнгөлөлттэй хамруулна.
1.3.3 Орчин үеийн дэвшилтэт технологи бүхий бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна.	Бага, дунд оврын жишиг загвар бүхий үйлдвэр байгуулахыг дэмжиж, үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна.	ХХҮХ, ЖДҮДТ	30-аас доошгүй жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийг "Хан-Уулд үйлдвэрлэв" сэтгүүлээр сурталчлах ажлыг зохион байгуулна.
ХОЁР. ЭРҮҮЛ ДҮҮРЭГ – ХҮНИЙ ХӨГЖИЛ			
2.1. Биеийн тамир, спорт			
2.1.2 Дүүргийн төрийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг жил бүр зохион байгуулна.	Дүүргийн Засаг даргын нэрэмжит нээлттэй тэмцээнийг ААН-үүдийн дунд жил бүр зохион байгуулна.	НХХ, БТСХ	Спортын арга хэмжээнд дүүргийн төрийн болон хувийн аж ахуй нэгж байгууллагуудын 1000-аас доошгүй албан хаагчийг хамруулсан байна.
2.2. Эрүүл мэнд			
2.2.9 Харшлын өвчин үүсгэгч ургамлыг устгах, тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор "Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулна.	"Харшилгүй эрүүл дүүрэг" аян жил бүр зохион байгуулж, олон нийтийн оролцоог хангана.	НХХ, ТНААХ	Сургалтыг зохион байгуулж, 5000-аас доошгүй иргэнийг хамруулна.
2.3. Цар тахлын үеийн бэлэн байдал			
2.3.1. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	ОБХ, МХХ, ЭМТ, ХУДНЭ, ЦГ, ЦЗХ	Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан шаардлагатай нөөцийг бүрдүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.
2.3.2 Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, заавар, зөвлөмж өгөх замаар ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ. зохион байгуулна.	Худалдаа үйлчилгээний байгууллага, зах, томоохон худалдааны төвүүдийн эрүүл ахуй, халдвараас сэргийлэх дэглэмийн мөрдөлт, халдваргүйжүүлэлтэд хяналт тавина.	ХХҮХ, МХХ	Худалдаа, үйлчилгээний 1600-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн ажиллана.
2.3.3 Гамшгийн үеийн бэлэн байдалтай холбоотой Хүнсээр хангах албаны мэргэжлийн ангийн тоог нэмэгдүүлж, хүнсний хангамжийг тогтворжуулна.	Дүүргийн Хүнсээр хангах албаны төлөвлөгөөнд тодотгол хийж, хүнсээр хангах мэргэжлийн ангиудтай хамтран ажиллаж, хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлнэ.	ХХҮХ	45-өөс доошгүй аж ахуйн нэгжтэй болзошгүй гамшиг ослын үед хүнс нийлүүлэх гэрээ байгуулж, шаардлагатай хүнсний нөөцийг бүрдүүлсэн байна.
2.3.4 Гол нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан тохиромжтой байршлуудад худалдан	Гол нэрийн хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн	ХХҮХ, ЖДҮТТ	Иргэдийн эрэлт хэрэгцээнд үндэслэн 2-оос доошгүй удаа худалдаа үйлчилгээ зохион байгуулж ажиллана.

Дүүргийн ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага	Хүрэх түвшин
борлуулах ажлыг дүүргийн хэмжээнд	худалдаа үйлчилгээ зохион байгуулж ажиллана.		
2.4. Хотын соёл			
2.4.1 Бүх шатны боловсрол соёлын байгууллагууд олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох "Хотын соёл" олон нийтийн аян өрнүүлэх	"Монгол үндэсний бахархлын өдөр"-ийг тохиолдуулан "Иргэний андгай өргөх ёслол"-ыг зохион байгуулах	УБХ	100 сурагч хамруулна.
2.4.2 Иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх үүднээс үндэсний бахархал, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж хэвшүүлнэ.	Дүүргийн Соёлын ордны барилгыг шинээр барих ажлыг талуудтай хамтран хэрэгжүүлнэ.	ТГУХ, НХХ, СО	Барилга ашиглалтад орсон байна.
ДӨРӨВ. НИЙГМИЙН ХӨГЖИЛ - ӨРХ БҮРТ			
4.5. Гэр бүл			
4.5.4 Залуучуудын хөгжлийг дэмжих, нийгмийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Залуучуудын хөгжил" дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.	Залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулах	НХХ, ЗХТ	500-аас доошгүй залуучуудыг чуулга уулзалтад оролцуулна.
ТАВ. ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ - ХОРОО БҮРТ			
5.1 Газрын харилцаа			
5.1.6 Туул тосгон Биокомбинат орчмын хайрганы карьераас үүдэлтэй газрын эвдрэл доройтлын судалгааг хийж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөхөн сэргээлт хийнэ.	Түгээмэл тархацтай ашигт малын олборлолтын улмаас эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээх ажлын эдийн засгийн тооцоо, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлнэ.	ТНААХ	Нөхөн сэргээх шаардлагатай газрын хэмжээг тодорхойлон, нөхөн сэргээх ажлын техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан нөхөн сэргээлт хийнэ.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД

Дүүргийн Засаг даргын 2024 оны Хариуцлагын гэрээний хэрэгжилт

2.4 Дүүргийн Засаг дарга нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2024 оны Хариуцлагын гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг эрчимжүүлж, бүрэн ханган хугацаанд нь гүйцэд тайлагнах,

Дүүргийн Засаг дарга нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2024 оны Хариуцлагын гэрээнээс эхний хагас жилийн байдлаар үр дүнгүй хэрэгжиж буй 20 арга хэмжээ;

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
Гурав. Дүүргийн Засаг даргын эрх, үүрэг		
3.2.Хууль тогтоомжийн хүрээнд:		
3.2.1.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх;		
1	3.2.1.1 25.1.2 Дүүргийн өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт;	ТЗУХ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ		Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
3	3.2.1.3	25.1.5 Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хуваарилалт болон бусад сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлан, хяналт;	ТЗУХ, СТСХ
5	3.2.1.5	25.1.8 Дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, соёлын төв, номын сан, биеийн тамир, спортын цогцолборын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалт, засвар;	ТГУХ, НХХ
9	3.2.1.9	25.1.12 Дүүргийн гэрэлтүүлэг, арчлалт;	ТНААХ, НҮА
10	3.2.1.10	25.1.13 Дүүргийн төвлөрсөн бус хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний УСТ цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалт;	ТНААХ, ГЗБА
3.2.3.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн заасан үүргийг хэрэгжүүлэх;			28.1 дэх хэсэгт
15	3.2.3.3	28.1.3 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх;	ХЭЗХ, ЦГ, ЗЦХ
17	3.2.3.5	28.1.5 Харьяа нутаг дэвсгэрийн иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулж байгаа ажлын талаар мэдээлэл өгөх;	ХЭЗХ, ЦГ, ЗЦХ
21	3.2.3.9	28.1.13 Гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байр бий болгох, хөдөлмөрлөх дадал, туршлага олоход нь дэмжлэг үзүүлэх;	ХЭЗХ, ЦГ, ЗЦХ
3.2.5.Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасан дүүргийн захирагч нарын бүрэн эрхийн хэрэгжилтэд хяналт тавих;			төсвийн шууд
26	3.2.5.1	Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавьж ажиллана.	ТЗУХ, СТСХ, ДАА
3.4.Нийгмийн салбарын хүрээнд:			
36	3.4.5	Эрүүл мэндийн байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд эмчилгээний тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг бүрдүүлэн, эмчилгээний тусламж, үйлчилгээ болон тусламж, үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авах эрхийг бүрдүүлж ажиллах;	НХХ-ЭМТ, НЭ
46	3.4.15	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд орчны эрсдэлийн үнэлгээг хийж, сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт, эрүүл ахуйн стандарт болон дотуур байрны орчин, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах;	НХХ, БХ
48	3.4.17	Ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн сурагчдад эрүүл мэндийг дэмжсэн “Өглөөний цай”, “Сүү” хөтөлбөрийг орон нутаг болон эцэг эхийн оролцоотойгоор төсөв санхүүжилтийг шийдвэрлэн зохион байгуулах;	НХХ, БХ
49	3.4.18	Багш, удирдах ажилтныг тогтвор суурьшилтай ажиллуулах, орон сууцны болон нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх орон нутгийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	НХХ, БХ
51	3.4.20	Дүүрэгт бүртгэлтэй өвлөн уламжлагчдыг дэмжих, урамшуулах, хамтарч ажиллах;	НХХ, Насан туршийн суралцах төв
54	3.4.23	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 378 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах (Залуучуудын хөгжлийн төв, бүтэц орон тоо, үйл ажиллагааг эрчимжүүлэх).	НХХ, ТЗУХ
3.5.Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хүрээнд:			
58	3.5.4	Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг бүрэн барагдуулж шийдвэрлэх, өмнөх оноос гомдлын тоог 30-иас доошгүй хувиар бууруулах;	ТЗУХ, холбогдох бүх хэлтэс, алба, ОНӨААТҮГ, байгууллагууд
59	3.5.5	Дүүрэг, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хийлгүүлж, дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.	ТЗУХ
3.8.Хотын стандартын хүрээнд:			
74	3.8.2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлыг хотын стандартын дагуу хангуулах, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчин, гудамж зам талбайг засварлаж тохижуулах ажлыг зохион байгуулах;	ТНААХ, НХХ, бүх хэлтэс, алба, ОНӨААТҮГ, байгууллагууд

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага
76	3.8.4 Дүүргийн хэмжээнд хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний үр дүнг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2024 оны эхний хагас жилд багтаан хотын стандарт, хяналтын газартай хамтарч танилцуулах.	ТНААХ
3.9.Бусад:		
86	3.9.10 Сайн засаглалыг хөгжүүлэх, цахим засаглалыг нэвтрүүлэх, дотоод удирдлага хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх;	ТЗУХ


Байгууллагад бүртгэгдсэн гомдол болон шийдвэрлэлтийн явцад бүртгэгдсэн зөрчил

2.5 Гомдлын тоо өссөнтэй холбогдуулан нийт хэлтэс, албад удаа дараа давтагдаж буй санал, хүсэлт, гомдолд онцгой анхаарах, агуулгаар нь ангилж, тухайн байгууллагын шуурхай болон даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, таслан зогсоох үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн үр дүнг тооцох;

2.6 Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээтэй гомдлууд эрс ихэссэнтэй холбогдуулан энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг орон нутгийн өмчит болон харьяа байгууллагуудад техник, технологийн дэвшлийг үе шаттай түргэн шуурхай нэвтрүүлэх арга хэмжээ авах,


2.7 Байгууллагын удирдах албан тушаалтнууд ирсэн өргөдлийг өдөрт нь багтаан хүлээн авч шилжүүлэх, хүлээн авсан албан хаагч явцын тэмдэглэл хөтөлж хэвших нь зүйтэй.

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2023, 2024 ОНЫ ХАГАС ЖИЛД БҮРТГЭГДСЭН ГОМДЛЫН ТОО




■ 2023 он ■ 2024 он


ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЁС ЗҮЙ, АЖЛЫН ХАРИУЦЛАГЫН ТАЛААР




БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР



БУСАД АСУУДЛААР БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ



ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2023, 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД БҮРТГЭГДСЭН ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ



ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ БАЙГУУЛЛАГУУДАД 2023, 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ

Байгууллага	Нийт /Өссөн дүнгээр/		Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил		Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй зөрчил	
	2023 III/25	2024 III/25	2023 III/25	2024 III/25	2023 III/25	2024 III/25	2023 III/25	2024 III/25	2023 III/25	2024 III/25
Боловсролын хэлтэс	6	5	4	3		1	2	1		
Биеийн тамир, спорт хороо										
Газар зохион байгуулалтын алба	33	19	14	13	2	4	17	2		
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс	16	11	1	6	7	1	8	4		
Нийгмийн даатгалын хэлтэс	2	14	1	9		1	1	4		
Онцгой байдлын хэлтэс	4	3	2				2	3		
Татварын хэлтэс	69	26	49	19	3	2	8	5	9	
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	10	8	5	4	1		4	2		2
Цагдаагийн 1 дугаар хэлтэс	7	2					7	2		
Цагдаагийн 2 дугаар хэлтэс	13	1					13	1		
Цагдаагийн газар	60	11	24	1	2	10	34			
Улсын бүртгэлийн хэлтэс	22	8			1	3	21	5		
Усан спорт сургалтын төв ОНӨУТҮГ										
Жижиг, дунд үйлдвэрлэлийн дэмжих төв										
Албан бус насан туршийн боловсролын төв	3				3					
Мэргэжлийн хяналтын хэлтэс										
Улаан загалмайн хороо										
Соёлын ордон										
Нийт	245	108	100	55	19	22	117	29	9	2

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ

Байгууллага	Нийт /Өссөн дүнгээр/		Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	
	2023 III/25	2024 III/25	2023 III/25	2024 III/25	2023 III/25	2024 III/25	2023 III/25	2024 III/25
Нэгдсэн эмнэлэг	4	9					4	9
Эрүүл мэндийн төв	5	4	1		4	4		
Туул тосгоны эрүүл мэндийн төв	7	17	2		5			17
Нийт	16	30	3	0	9	4	4	26

ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРУУДАД
БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ

Байгууллага	Нийт /Өссөн дүнгээр/		Явцын тэмдэглэл хөтлөөгүй		Өдөрт нь багтаан шилжүүлээгүй		Өдөрт нь багтаан хүлээн аваагүй		Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй	
	2023 VI/25	2024 VI/25	2023 VI/25	2024 VI/25	2023 VI/25	2024 VI/25	2023 VI/25	2024 VI/25	2023 VI/25	2024 VI/25
Хан-Эко хотын тээвэр ОНӨААТҮГ	2	1					2	1		
Тохжилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	8	11		1		6	8	2		2
Хан-Уул Агро ОНӨААТҮГ		1						1		
Зам засвар арчлалт ОНӨААТҮГ										
Эко ахмадын сувилал		3		3						
Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ	3	8					3	8		
Эко хотын тээвэр ОНӨААТҮГ										
Яармаг ОНӨААТҮГ		7				7				
Нийт	13	31	0	4	0	13	13	12	0	2

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХҮРЭЭНД

3.8 Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан журамд тусгасан 53 шалгуур үзүүлэлтээс дүүргийн Засаг даргын 2022 онд баталсан хуваарийн дагуу Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хориглосноос бусад холбогдох мэдээллийг дүүргийн болон байгууллагын цахим хуудсанд хуулийн хугацаанд байршуулах,

3.9 Дүүргийн цахим хуудсанд байгууллагын үйлчилгээний нэр төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, зохицуулалтын үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлөх дансны мэдээллийг тухай бүр шинэчилж хэвших,

3.10 Орон нутгийн өмчит байгууллагууд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явцыг цахим хуудсандаа хуулийн хугацаанд байршуулах,

3.11 Байгууллагын албан ёсны цахим хуудсаа Хан-Уул дүүргийн албан ёсны www.khanuul.mn цахим хуудастай холбож, мэдээллийн баяжилтыг тогтмол хийж, иргэдэд ойлгомжтой байдлаар мэдээллийг нээлттэй болгох чиглэлээр бүх сурвалжийг ашиглах,

3.12 Дүүргийн khanuul.mn цахим хуудсанд байршуулах өөрийн байгууллагатай холбоотой, хуулинд заасан мэдээллүүдийг Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь өгч, тухай бүр шинэчлэлт, баяжилтыг тусгуулах албан тушаалтныг хэлтэс, байгууллага бүр дотооддоо томилж, албан тушаалын тодорхойлолтод нь нэмэлтээр тусган ажлын үр дүн, гүйцэтгэлийг тооцож, дүгнэн хариуцлагажуулж ажиллах нь үр дүнтэй.

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ БОДЛОГЫН ХҮРЭЭНД

4.13 Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус төр, хувийн хэвшил, хамт олны хүрээнд өмнө жилүүдэд тарьсан бүх мод, бут, сөөгний арчлалт, хамгаалалт, ургалтын явцыг анхаарч, хяналт тавьж, баримтжуулан жил бүр тарьсан мод болон ургалтын тоо, чанарыг хянан үр дүнг тооцож хэвших,

4.14 Байгууллагын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр үр дүнтэй арга, туршлага нэвтрүүлж, хэвшил болгох,

4.15 E-mongolia цахим систем хэрэглэгч байгууллагууд тухайн салбар, нэгжийн үйлчилгээний төрөл, үр дүнг цахим хуудсандаа байршуулбал зохистой.

ЗӨВЛӨМЖ ХЯНАСАН:

Л.ОТГОНБАЯР
Хяналт-шинжилгээ, үнэлгээний
хэлтсийн даргын албан үүргийг хавсран
гүйцэтгэгч

ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН:

Н.АЛДАРМАА
Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан
мэргэжилтэн